



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

Э-сонин

6-Р САР

59-р дугаар






Үнэт цаасны зах зээл

Зах зээлийн тойм


/2018.06.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	13,231,018,859.85
Хувьцаа /анхдагч/	2,495,296,000.00
Хувьцаа /хоёрдогч/	8,714,679,299.85
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	2,012,443,560.00
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	8,600,000.00
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	35,045,215
Хувьцаа /анхдагч/	3,898,900
Хувьцаа /хоёрдогч/	31,126,925
Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/	19,304
Компанийн бонд /анхдагч/	0
Компанийн бонд /хоёрдогч/	86
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	6,143


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	220
100% төрийн өмчит	19
Төрийн өмчийн оролцоотой	12
Хувийн өмчийн	189
I ангилал	9
II ангилал	42
III ангилал	169

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	59
Үүнээс: Брокер, Дилер	50
Андеррайтер	23
Хөрөнгө оруулалтын зөвлөх	13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны гишүүн компаниуд

/2018.06.30-ны байдлаар/

Симб ол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	БиДиСек ХК	16,112,873	5,094,747,039.32	16,444,915	5,117,269,958.70	10,212,016,998.02
2	Бумбат-Алтай ХХК	2,126,037	912,831,373.86	2,406,142	960,800,845.01	1,873,632,218.87
3	Голомт Капитал ХХК	1,835,620	684,347,626.86	924,246	193,807,755.45	878,155,382.31
4	Гаули ХХК	1,611,731	493,832,235.38	253,985	130,520,766.17	624,353,001.55
5	Ти Ди Би Капитал ХХК	1,779,507	359,538,428.51	749,835	228,019,729.03	587,558,157.54
6	Стандарт инвестмент ХХК	649,156	196,030,326.61	1,706,756	349,631,851.15	545,662,177.76
7	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	4,708,849	294,384,797.31	2,366,789	231,130,228.64	525,515,025.95
8	Новел инвестмент ХХК	362,897	159,865,937.59	1,654,552	208,580,269.76	368,446,207.35
9	Гендекс ХХК	7,662	3,731,790.00	361,102	212,875,383.55	216,607,173.55
10	Ард секюритиз ХХК	436,060	113,895,821.33	167,804	69,347,432.72	183,243,254.05
11	Зэргэд ХХК	83,989	23,913,266.79	213,460	124,525,293.70	148,438,560.49
12	Тэсо Инвестмент	72,009	91,415,530.00	101,132	51,103,765.90	142,519,295.90
13	Ард капитал групп ХХК	490,148	59,797,061.96	438,760	80,604,063.77	140,401,125.73
14	Санар ХХК	2,951	1,697,007.00	242,496	136,482,048.00	138,179,055.00
15	Евразиа капитал монголиа ХХК	41,628	36,178,107.89	461,463	80,843,440.39	117,021,548.28
16	Монсек ХХК	233,674	31,300,166.28	247,638	68,672,221.63	99,972,387.91
17	Батс ХХК	86,544	13,675,177.00	1,059,367	83,428,654.40	97,103,831.40
18	Дархан брокер ХХК	10,545	15,429,559.50	129,349	57,663,812.30	73,093,371.80
19	Мэргэн санаа ХХК	30,416	11,483,143.30	83,849	38,809,964.50	50,293,107.80
20	Дэлгэрхангай секюритиз ХХК	329	7,331,300.00	69,704	41,597,853.39	48,929,153.39

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.06.30-ны байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт %/
1	BDS	БИ ДИ СЕК	2,012,943	2,013,245,688.00	1,147.00	1,000.00	-97.00	-8.46
2	SHV	ШИВЭЭ ОВОО	471,436	966,710,726.00	2,350.00	2,050.00	-1.00	-0.05
3	APU	АПУ	1,395,648	833,740,504.47	650.00	575.00	5.39	0.86
4	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	2,099,674	826,747,249.60	419.00	371.00	-8.12	-1.97
5	APU	АПУ	1,071,385	718,899,335.00	671.00	671.00	0.00	0.00
6	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,823,945	547,185,400.00	320.00	290.00	-27.41	-7.89
7	LEND	ЛЭНДМН БЭСЬ ХК	9,395,334	533,626,260.69	60.00	52.00	5.19	10.13
8	HGN	ХӨХ ГАН	5,172,967	439,870,014.50	95.00	85.00	10.00	11.76
9	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	5,146,477	437,104,889.40	90.00	65.00	0.00	0.00
10	GOV	ГОВЬ	14,965	352,643,340.00	27,000.00	22,100.00	1,120.00	4.89
11	TTL	ТАВАН ТОЛГОЙ	28,198	280,954,645.00	10,350.00	9,500.00	-365.00	-3.64
12	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	348,056	229,980,297.58	698.00	610.00	650.00	0.00
13	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	8,578	81,100,150.00	9,500.00	9,000.00	-1,920.00	-17.58
14	MIB	МОНИНЖБАР	409,500	61,425,000.00	150.00	150.00	-20.00	-11.76
15	JIV	ЖИНСТ-УВС	29,347	43,372,837.00	1,501.00	1,411.00	-10.00	-0.67
16	SUU	СҮҮ	192,177	41,130,238.90	226.00	205.00	-9.39	-4.18
17	BAZ	ЛЮКС ЗАНАДУ ГРУПП	39,777	35,026,432.89	880.57	880.57	114.85	15.00
18	ITLS	АЙТҮҮЛС	237,531	30,731,043.47	137.00	126.00	-6.00	-4.41
19	MNP	МОНГОЛ ШУУДАН	52,778	30,582,830.00	600.00	568.00	8.26	1.45
20	HBO	ХАЙ БИ ОЙЛ	495,158	27,476,104.90	67.00	55.00	-4.50	-6.72



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.06.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2018-06-01	2018-06-30		
1	АЛТАЙН ЗАМ	16	2,439	9,845.00	7,406.00	303.65
2	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	14,013	123	247.45	124.40	101.10
3	БАЯЛАГ НАЛАЙХ	485	236	311.00	75.25	31.92
4	ЛЮКС ЗАНАДУ ГРУПП	39,777	766	880.57	114.85	15.00
5	ХҮРД	70	1,610	1,851.00	241.00	14.97
6	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	198	684	780.00	95.61	13.97
7	ХӨХ ГАН	5,172,967	85	95.00	10.00	11.76
8	ЛЭНДМН ББСБ ХК	9,395,334	51	56.40	5.19	10.13
9	МЕРЕКС	336,746	30	33.00	3.00	10.00
10	ГОВЬ	14,965	22,900	24,020.00	1,120.00	4.89
11	МИК ХОЛДИНГ	19	10,500	11,000.00	500.00	4.76
12	МОНГОЛ НЭХМЭЛ	50	3,596	3,700.00	104.00	2.89
13	ШАРЫН ГОЛ	2,604	2,203	2,250.00	47.00	2.13
14	УБ-БҮК	5,003	416	425.00	8.54	2.05
15	ТЭЭВЭР ДАРХАН	624	12,800	13,000.00	200.00	1.56
16	МОНГОЛ ШУУДАН ХК	52,778	570	578.26	8.26	1.45
17	АПУ	1,395,648	628	633.39	5.39	0.86
18	ИХ БАРИЛГА	10	3,685	3,699.00	14.00	0.38
19	СТАНДАРТ НООС	10	500	500.00	0.00	0.00
20	АВТО ИМПЕКС	15	2,200	2,200.00	0.00	0.00

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.06.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-06-01	2018-06-30		
1	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	600	880	470.00	-410.00	-46.59
2	МАТЕРИАЛИМПЕКС	8,578	10,920	9,000.00	-1,920.00	-17.58
3	АДУУН ЧУЛУУН	2,399	2,714	2,300.00	-414.00	-15.25
4	НОЁТ ХАЙРХАН	3	1,322	1,125.00	-197.00	-14.90
5	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	23	1,150	985.00	-165.00	-14.35
6	МОНГОЛЫН ЦАХИЛГААН	1,778	560	480.00	-79.91	-14.27
7	АГРОТЕХИМПЕКС	39	1,237	1,075.00	-162.00	-13.10
8	МОГОЙН ГОЛ	124	9,200	8,000.00	-1,200.00	-13.04
9	БИНСЭ ХК	390	403	350.00	-52.50	-13.04
10	БЭРХ УУЛ	1,274	839	730.00	-109.00	-12.99
11	МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ	13	5,900	5,200.00	-700.00	-11.86
12	МОНИНЖБАР	409,500	170	150.00	-20.00	-11.76
13	ГУТАЛ	618	22,000	19,500.00	-2,500.00	-11.36
14	ОЛЛОО	4,724	67	60.01	-6.98	-10.42
15	ДАРХАН ХӨВӨН	151	14,500	13,000.00	-1,500.00	-10.34



"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН" МХБ-ИЙН АРИЛЖААНЫ НЭЭЛТЭЭ НЭЭЛЭЭ

Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол улсад ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" Монголын хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлж, үнэт цаасны давхар бүртгэл Монголын хөрөнгийн зах зээлд нэвтэрч буй онцгой үйл явдлыг тохиолдуулан Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамны сайд Д.Сумъяабазар, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга С.Даваасүрэн, "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн ерөнхийлөгч Петер Акерли нар өнөөдөр буюу 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Монголын хөрөнгийн биржид хүрэлцэн ирж, үнэт цаасны 5,736 дахь удаагийн арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохих ёслолд оролцлоо.

Энэхүү ёслолын ажиллагааны үеэр "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн ерөнхийлөгч Петер Акерли хэлэхдээ "Үнэт цаасаа давхар бүртгүүлэхээр Монгол улсын Засгийн газар, Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг байгууллагуудтай нягт, үр бүтээлтэй хамтран ажилласны үр дүн биеллээ олж байгаад баяртай байна. МХБ-д үнэт цаасаа давхар бүртгүүлэн арилжих болсноор Монгол улсын иргэд Эрдэнийн хувьцааг худалдан авч, алтны үндсэн ордын хайгуулын төслүүдийн үр өгөөжийг хамтран хүртэх боломжийг бий болголоо. Түүнчлэн, үнэт цаасны энэхүү давхар бүртгэл Монгол улсад анх удаа хийгдэж байгаагаараа онцлог бөгөөд Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэг шатаар ахиулахын зэрэгцээ уул уурхайн компаниудын ил тод байдал, сайн засаглалын шинэ жишгийг тогтооно гэдэгт итгэж байна" хэмээн онцоллоо.

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН"-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА НИЙЛҮҮЛТЭЭСЭЭ 66 ХУВИАР ДАВЖ ХААГДЛАА

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн анхны давхар бүртгэлтэй компани болох "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" нь нийт хувьцааны 2.7% буюу 3,898,900 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 15:00 цаг хүртэл авч дууслаа.

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад 1,248 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 6,478,146 ширхэг худалдан авах захиалга ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон дүнг даруй 66 хувиар давсан үзүүлэлт боллоо.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн"-ийн хоёрдогч зах зээлийн арилжаа 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр эхэллээ.

"МОНГОЛ ШИР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Монгол шир" ХК-ийн 2017 оны 12 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо "Монгол Шир" ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан тул хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй эсхүл энэхүү шийдвэрийн эсрэг саналтай байсан саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд дараах эрх үүссэнийг мэдэгдэж байна. Үүнд:

1. "Монгол шир" ХК-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшиж байгаа хувьцааг нэг бүрийг нь 2714 /хоёр мянга долоон зуун арван дөрөв/ төгрөгөөр эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй. Энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн харьяа гишүүн үнэт цаасны компани эсвэл "БиДиСЕК ҮЦК" ХК болон "Монгол шир" ХК-д хандана уу.
2. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг авалгүйгээр компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргах эрхтэй.
3. Шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаа: 2018 оны 7-р сарын 24-ний өдөр Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авна уу.
"Монгол Шир" ХК
Хаяг: ХУД, 2-р хороо, АШҮХ-нд компанийн өөрийн байр, Утас: 99105418, 99025111, 99040007
"Би Ди СЕК ҮЦК" ХК
Хаяг: СБД, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1 байр, Утас: 11-313108, 11-321763



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Монгол Базалт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2017 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 180611 тоот шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр зарлан хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2018.07.27, 14:00 цагт

Бүртгэх өдөр: 2018.07.02

Хуралдах газар: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Корпорейт зочид буудлын хурлын танхимд хуралдана.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн дүрмийг багтах тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд УБ хот, СБД 1-р хороо, Фламинго Тауэр, 7 давхарт

Хурал зохион байгуулах комисс: ТУЗ-ын нарийн бичгийн дарга Х.Одончимэг 7511-4444, 99874150, Имэйл: Odonchimeg.Bazalt@gmail.com

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ, ГОЛОМТ БАНК ХАМТАРСАН СУРГАЛТ ЯВУУЛНА

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2005 оноос эхлэн сар бүр зохион байгуулж ирсэн үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалтын цар хүрээг өргөтгөж ААН, мэргэжлийн хөрөнгө оруулагч бэлтгэх дунд, ахисан шатны сургалтуудыг Голомт банкт хамтарч зохион байгуулахаар төлөвлөд байна.

Энэхүү арга хэмжээний эхлэл болгон Голомт банкт хамтран тохижуулсан Сургалтын танхимыг өнөөдөр нээсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Х.Алтай болон Голомт банкны гүйцэтгэх захирал Ө.Ганзориг нар цан цохиж 5746 дахь өдрийн арилжааг эхлүүлээ.

“АЛТАЙН ЗАМ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ТҮР ЗОГСООЛОО

“Алтайн зам” ХК-ийн үнэт цаас цөөн тоогоор удаа дараа арилжаалагдаж үнэт цаасны үнэ огцом өссөн нь ҮЦЗТХууль болон бусад холбогдох журмуудыг зөрчсөн байж болзошгүй гэж үзсэн тул СЗХ-ны улсын байцаагчийн 2018 оны 6 сарын 18-ны өдрийн 38 тоот албан шаардлагаар “Алтайн зам” ХК-ийн үнэт цаасны арилжааг зөрчлийн хэрэг бүртгэлийн хугацаа дуусах хүртэлх хугацаагаар түр зогсоолоо.

ОРОН НУТАГТ ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ БОЛЛОО

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аас орон нутгийн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг

дээшлүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, үнэт цаасны компаниуд болон “Эрдэнэс таван толгой” ХК-тай хамтран Дархан-Уул, Булган, Орхон аймгуудад “Үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөг” арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 21-нээс 23-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр хөрөнгийн зах зээлийн суурь ойлголтууд, хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох, хөрөнгийн зах зээлээс компаниуд санхүүжилт татах боломж зэрэг сэдвээр сургалт явуулснаас гадна Эрдэнэс таван толгой ХК-ийн үйл ажиллагаа, иргэдэд олгосон хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 1991 оны хөрөнгө оруулалтын эрхийн бичигтэй /ягаан цэнхэр тасалбар/ холбоотой дансны мэдээллийг шүүх, ногдол ашгийн мэдээллийг өгөх, арилжааны данс нээх, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэргээр нийт 3000 гаруй иргэдэд нэг цэгийн цогц үйлчилгээг үзүүллээ.

Нээлттэй өдөрлөг арга хэмжээг орон нутгийн иргэд талархалтайгаар хүлээн авч үйлчлүүлсэн бөгөөд оролцогч байгууллагууд хамтран цаашид бусад аймгуудад уг арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөд байна.



“СҮҮ БОНД”-ЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙГДЛЭЭ

МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК нь 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр “Сүү Бонд”-ыг МХБ-ээр дамжуулан арилжаалж олон нийтээс 6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь МХБ-ийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй компанийн өрийн хэрэгсэл болсон билээ.

Тус өрийн хэрэгслийг “Сүү” ХК нь өөрийн хувьцаагаар баталгаажуулан гаргасан бөгөөд жилийн 17.5 хувийн хүүтэй буюу банкны хадгаламжаас өндөр өгөөжтэй байсан нь хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээс гадна олон ААН-үүдэд бага зардлаар өөрсдийн бизнесийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой болохыг харуулж чадсан юм. Мөн “Сүү бонд” нь хоёрдогч зах зээл дээр идэвхтэй арилжаалагдаж, өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийт 4.8 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2018 оны 6 сарын 29-ний өдөр “Сүү” ХК нь бонд эзэмшигчдийнхээ дансанд бондын эргэн төлөлтийг хүүгийн хамтаар байршуулснаар хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ 100% биелүүлж, МХБ-тэй байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний үр дүнг дүгнэлээ.

“Сүү Бонд”-ын үндсэн андеррайтераар “Толомт Капитал ҮЦК” ХХК, туслах андеррайтераар “Ард Капитал Групп ҮЦК” ХХК, “Тэнгэр Капитал ҮЦК” ХХК-ууд хамтран ажилласан болно.

“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ ЗОГСООЛОО

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн 2018 оны 4 дүгээр сарын 2-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэмж хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн бөгөөд нэмж хувьцаа гаргах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэнтэй холбогдуулан үнэт цаасны арилжааг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн зогсоолоо.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN